



БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Барилгын дүрэм батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Геодези зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.4 дэх заалт, Барилга, хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Ус, дулаан хангамж, ариутгах татуургын сүлжээ, үерийн усны байгууламжийн геодезийн ажил” БД 11-115-16 дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан барилгын дүрмийг геодези, зураг зүйн ажилд мөрдүүлэхийг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар /А.Хүрэлшагай/-т, нийтэд мэдээлэх, хэвлэн түгээх ажлыг зохион байгуулахыг “Барилга хөгжлийн төв” ТӨҮГ /Б.Баярсайхан/-т, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газар /Б.Ууганбаяр/-т тус тус даалгасугай.

САЙД



З.БАЯНСЭЛЭНГЭ

Com /d/ tushaal-2015

08 000108